

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, Үр дүн	Төсөв /сая төг/ Хөрөнгийн эх үүсвэр	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хүрээнд							
4.1 Газар тариалангийн чиглэлээр:							
4.1.1	АЗДҮАХ 4.1.16 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.20	Өвлийн нарлаг хүлэмжийг шаардлагатай тоног төхөөрөмж, дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлэж хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	Хүлэмжийн ашиглалтыг сайжруулж, тариалсан талбай болон ургацын хэмжээг нэмэгдүүлэх	2019 онд хураан авах ургацын 3,5 тн-оор нэмэгдүүлж, өмнөх оноос хэрэгцээг 22,5 %-аар нэмэгдсэн байна.	2,3 Хувийн хөрөнгө оруулалт 29.5 ОНТ	Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамжийн ажлыг АНАРЗОНЕ ХХК 2019 оны 12 дүгээр сарын 30-ны өдөр дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. ОНХС-ийн 23,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар уг ажлыг хийж гүйцэтгэснээр хүнсний ногоо тасралтгүй тариалах боломж бүрдэнэ. Дэлгэрцогт, Сайнцагаан сумдын өвлийн хүлэмжинд 1473 М2 талбайд тариалсан, талбайн хэмжээ урьд оноос 273 м2 –аар нэмэгдэж. Хураан авсан ургац урьд оноос 3,3 тн-оор нэмэгдэж, орон нутгийн хүнсний ногооний хэрэгцээний 25%-ийг хангасан байна.	100
4.1.2	АЗДҮАХ 4.1.15 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.22	Засгийн газрын 223, 278 дугаар тогтоолоор батлагдсан “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Аймгийн хэмжээнд нийт тариалсан талбай 64,1 га-д чацаргана тариалсан байна. 2018 онд жимс жимсгэний тариалсан талбай 3,2 га-р нэмэгдүүлэх	Тариалалтын талбай 5 га, хураан авах ургацын хэмжээ 25 тн-оор нэмэгдсэн байна	ТЭДС-12.0 Хувийн хөрөнгө-30.0	ИТХ-ын 2019 оны А/25 тогтоолоор “Жимс жимсгэнэ” “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрүүдийг батлуулсан. ХХААХҮЯ-аас хүлэмжийн аж ахуйн тариалалтын талбайг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэгдэж байгаа 4х8 хэмжээтэй 4 ширхэг хүлэмж, мөн жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд Чацаргана, Бэсрэг алимны суулгац 628 ширхэгийг тус тус захиалж Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт, Говь-Угтаал сумдад олгосон. Энэхүү	100

						суулгацын авсанаар шинээр 0,6 га-д нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд нийт 2 ААН, 100 иргэн нийт 41,9 га-д талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалсан. Үүнд: төмс 21,4 га-гаас 208 тн, хүнсний ногоо 13,3 га-гаас 118 тн, малын тэжээлийн ургамал 2,8 га-гаас 10,5 тн, жимс жимсгэнэ 8,7тн тус тус хураан авсан байна. Урьд оноос хураан авсан ургац 138,2 тн-оор нэмэгдсэн байна.	
4.1.3	АЗДҮАХ 4.1.15 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.17	Онги голыг түшиглэн усалгаатай газар тариалангийн /төмс, хүнсний ногоо, чацаргана/ тариалалтыг дэмжинэ.	Усалгаатай талбайг нэмэгдүүлэх хэмжээ, га	10 га талбайн усжуулалтын системийг шийдвэрлэж тариалан эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.		Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын шинээр Онги голын түшиглэн 10 га талбайн усжуулалтын системийг 90,0 сая төгрөгийн зураг төсөв хийлгэсэн. 2019 онд төмс 5,3 га-гаас 59,5 тн, хүнсний ногоо 1,9 га-гаас 19,5тн, чацаргана 8,5 га-гаас 5,1 тн тус тус хураан авсан байна. Урьд оноос харьцуулахад хураан авсан ургацын хэмжээ 43,8 тн-оор өссөн байна. Сайхан-овоо сум нь төмсний хэрэгцээг 36,2 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 6,4 хувь, чацаргана 4,1 хувиар хүн амын хэрэгцээг хангаж байна.	100
4.2 Мал аж ахуйн салбарын чиглэлээр:							
4.2.1	АЗДҮАХ 4.1.1	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	Улсын төсөв болон бусад эх үүсвэр	2019-2020 онд хэрэгжүүлэх 32 заалт бүхий төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 92,5% хэрэгжиж байна.	100
4.2.2	АЗДҮАХ 4.1.2, 4.1.3	“Залуу малчин”, “Илгээлтийн эзэд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	0,210 УТ	2019 Онд хэрэгжүүлэх 12 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай хангагдаад байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зах зээлийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүд давамгайлсан 30 гаруй бүлгийг 294 иргэнийг хамруулсан “Бизнес төлөвлөгөө, зээлийн төсөл боловсруулах,”	100

						<p>“Сүү боловсруулах технологи”, “Ногоо боловсруулах технологи”-ийн сургалтыг зохион байгуулж “Чадамжийн гэрчилгээ” олголоо.</p> <p>Мөн Эрдэнэдалай сумын Содбриллант, Дэлгэрцогт сумын “Номын өргөө” ХХК-иудын үнээний ферм, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тус бүр 50,0 сая төгрөгийн, Сайнцагаан сумын “Тэнүүн говийн баялаг” ХХК-ны эсгийний үйлдвэрийн 90,0 сая төгрөгийн, Сайхан-Овоо сумын Чацаргана төгөл хоршооны чацаргана боловсруулах 50 сая төгрөгийн төслүүд тус тус дэмжигдсэн.</p>	
4.2.3	Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	<p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн тогтолцоог бий болгоно.</p>	<p>-Малын гаралтай түүхий эдийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>-Хонины ноосыг үндэсний үйлдвэрт тушаасан тн-оор</p>	<p>-Арьс шир боловсруулах анхан шатны үйлдвэр 1-ээс доошгүйг байгуулсан байна.</p> <p>-Хонины ноосыг үндэсний үйлдвэрт тушаан утас, даавууг авч сумдад оёдол, сүлжмэлийн жижиг үйлдвэр байгуулагдсан байна.</p>	-	<p>Монгол улсын Засгын газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, хонь, тэмээний ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг орон нутагт хэрэгжүүлэн 2018 оны сүүлийн хагас жилийн арьс ширний урамшууллын материалыг 2178 өрх 5403 падаанаар 210378 арьс ширийг 18 төлөөлөгч үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан баримтыг сумдаас хүлээн авч мал хамгаалах санд, 02 сард Засгийн Газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу тэмээ, хонины ноосоо итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан 724378 кг хонины ноос, 4727 кг тэмээний ноосны материалыг хүлээн авч ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн малчдын урамшууллын материалыг сумдаас хүлээн авч ноосны урамшууллын программд оруулах ажил хийгдэж дууссан. Энэ онд 4727 тн тэмээний ноос, 724378 тн хонины ноосыг үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан.</p>	70

						Хэрэгжилт 100 хувь. Мал хамгаалах сан татан буугдсантай холбоотойгоор энэ оноос эхлэн малчдын арьс шир, ноосны урамшууллын материал эцэслэгдэн ХХААГ дээр төвлөрч, ХХААХҮЯ-руу санхүүгийн баримтыг илгээдэг зохицуулалтад орон ажиллаж байна. СХСангаас Цагаандэлгэр, Гурвансайхан сумдад нэхий элдэх чиглэлээр 4 иргэнд 54,0 сая төгрөгний зээлийг олгосон байна. Шинээр 9 ажлын байр бий болсон.	
4.2.4	АЗДҮАХ 4.1.1 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.5	Малын нөхөн үржихүйн биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, гүн хөлдөөсөн үр, үйлдвэрлэх чадавхи, бүтээмжийг нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэнэ.	Зохиомлоор хээлтүүлэх аргыг нэвтрүүлсэн байх	Цөм сүрэг бүхий шилмэл ангийн 1000 хонинд зохиомол хээлтүүлэг хийгдсэн байна.	-	2019 оны төсөвт Сайнцагаан хонийг омог болгох ажлын хүрээнд аймгийн төсвөөс 10 сая төгрөгний зардлын тооцоо хийж өгсөн боловч дэмжигдээгүй. Зохиомол хээлтүүлгийг Сайнцагаан хонинд түшиглэсэн боловч хөрөнгө санхүүгийн дутагдал, цаг агаарын байдал хүндэрч айл өрхүүд зохиомол хээлтүүлэг болон ердийн хээлтүүлгийг зохион байгуулаагүй.	ҮБ
4.2.5	АЗДҮАХ 4.1.4	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна.	Авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр	Аймгийн хэмжээнд 50 мян/га-с доошгүй талбайг хамруулсан байна.	80.0 Аймаг, сум орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Бэлчээр хамгаалах хаврын арга хэмжээ: үлийн цагаан оготной 45 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик болон микробиологийн аргаар тэмцлээ. Тус аймагт зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах команд штабын улсын үзлэгийн үеэр мэргэжлийн анги албадын нийт 303 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дэрэн сумын Алаг-Өндөр багийн нутагт 25 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар, 10 сумын 20 мян/га талбайд 40 тн бактержуулсан бэлдмэл цацаж улсын төсвөөс нийт 237,7 сая төгрөгийг зарцуулан 85,0 хувийн хээрийн техникийн үр дүнтэй зохион байгуулсан. Бэлчээр хамгаалах намрын арга хэмжээ: Улсын төсвийн 125 сая төгрөгөөр 9 сумын 50 мян/га бэлчээрт үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх ажлыг 85,3	100

					хувийн хээрийн техникийн үр дүнтэй зохион байгуулсан. Нийт 95 мян/га бэлчээрт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг улсын төсвийн 362,7 сая, орон нутгийн 1,7 сая төгрөгөөр зохион байгууллаа. Орон нутгийн 1,7 сая төгрөгөөр 43 ширхэг шувууны үүр хийсэн.	
	Аймгийн бэлчээрийн менежментийг сайжруулах 2019 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 80-аас доошгүй хувьд хүргэнэ.	139,0 УТ 161,0 Төсөл хөтөлбөр	Аймгийн бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр 2019 онд хийх 29 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан ХОХБТХ-ийн даргаар батлуулж хэрэгжилтийг 85 хувиар хангасан. Төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн гол ажлуудаас дурьдахад: 1. Төсөл, хөтөлбөр болон сумдын өөрсдийн санаачлагаар 11 инженерийн хийцтэй худгийг шинээр, 30 энгийн уурхайн худгийг сэргээн засварлаж бэлчээр усжуулахад 289,6 сая төгрөгийг зарцуулж өмнөх оноос блчээр усжуулалт 1,8 хувиар нэмэгдсэн. 2.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон сум орон нутгийн нийт 364,411,000 төгрөгний хөрөнгө оруулалтыг бэлчээр, хамгаалахад зарцуулж, 10 сумын 95,0 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг зохион байгуулсан. Бүх сумдад сумын бэлчээр ашиглагчдын холбоог байгуулсан. Малын тэжээл тариалах талбайн хэмжээ, ургацыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан. Луус сумын Суврага багийн 7 малчин өрхийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж 1 гүн өрмийн худаг шинээр гарган сэргээгдэх эрчим хүчийг суурилуулан 2 га бэлчээрийн талбайд малын тэжээлийн ургамал тариалсан. Хулд, Өндөршил, Цагаандэлгэр сумдад 2,8 га талбайд нийт 4,8 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж, 10,5 тн ургац хураан авч, өмнөх оноос тариалсан талбай	100

						4,5 га-с хураан авсан ургац 7,3 тн-р нэмэгдсэн зэрэг үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан.	
4.2.6	АЗДҮАХ 4.1.5	“Тэмээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэн сүргийн тоо толгой, тархацыг нэмэгдүүлж, малын чанарыг сайжруулна.	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	Төмөр сүргийн тоо толгойг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, Олдохын хүрэн бор тэмээнээс өсвөр хээлтүүлэгч 10-аас доошгүйг бойжуулж сайжруулагч-аар ашиглана.	2,0 Улсын төсөв	Хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. МAAЭШХ-ийн эрдэмтдийн багтай хамтран Олдохын хүрэн бор тэмээ 3000-д омог болгох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Олдохын хүрэн бор тэмээнээс 10 өсвөр хээлтүүлэгч бойжуулан сүргийн тархацыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулж байна. Засаг даргын 2017.12.19-ний А/469 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг гарч 2017, 2018 онуудад Өлзийт сумнаас Говь-Угтаал суманд ирсэн 34 ингэ нь 23 өрхөд байгаа ба 2017 онд ирсэн 12 ингэ 7 торомтой, 2018 онд ирсэн 22 ингэ 20 ботготой байна. Төмөр сүргийн тоо 27 толгойгоор өссөн байна.	100
4.2.7	АЗДҮАХ 4.1.9	Хулд сумын тэмээ, Өндөршил сумын адуу, Сайнцагаан хонинд шинжилгээ судалгааг үргэлжлүүлэн, омгоор батлуулна.	МAAЭШХүрээлэнгийн эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн удам зүйн үнэлгээний санд бүртгүүлж баталгаажуулсан байх	Хулд сумын Олдохын хүрэн бор тэмээ, Өндөршил сумын Шилийн адуунд хувьслын ангилалтад 2000, хонь 5000-ыг хамруулан хийсэн байна.	20,0 Улсын төсөв	Омгийн хянан магадлагааны улсын комисс орон нутагт ажиллаж Өндөршил адуу 3000, Сайнцагаан хонь 20000, Олдохын хүрэн бор тэмээ 3000 толгойд тус тус хувьслын үзлэг ангилалт хийсэн. ХХААХҮСайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-445 дугаар тушаалаар Өндөр шил адууны омгийг баталгаажуулсан. Сайнцагаан хонины судалгааны ажил ХХААХҮСайдын зөвлөлийн хурлаар омог болон баталгаажуулах шийдвэр гарсан Сайдын тушаал одоогоор гараагүй байна.	100
4.4 Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны чиглэлээр:							
4.4.1	АЗДҮАХ 4.2.5 Гурван тулгуурт хөгжлийн	Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөнийг 2019 оны эхний хагас жилд	Салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцож, зөвлөмж гарган хэрэгжүүлэх	Зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө батлагдаж хэрэгжилт 90-ээс		Бүтээн байгуулалт-Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд 6 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Дундговь аймаг, ӨМӨЗО-ы Баяннуур аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтарсан, үзэсгэлэн худалдаа, зөвлөгөөн боллоо.	100

	<p>бодлого 3.1.1.24</p>	<p>багтаан салбарын эдийн засгийн хөгжлийг хангах зорилгоор холбогдох газруудтай хамтран зохион байгуулна.</p>		<p>доошгүй хувьд хүрсэн байна. Ажиллагсдын мэдлэг чадвар, үйлчилгээний чанарт ахиц гарч стандартын үнэлгээний түвшин өмнөх оноос 5 хувиар нэмэгдсэн байна.</p>	<p>Зөвлөгөөнд хоёр аймгийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн төлөөллүүд оролцож, харилцан туршлага солилцон, бараа бүтээгдэхүүнээ сурталчлан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, аймаг, орон нутгийн эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг нэмэгдүүлэн, хөгжүүлэх талаар ярилцсан байна. Зөвлөгөөний үеэр жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрийн талаар мэдээ мэдээллийг хүргэж, тэдний үйл ажиллагааг дэмжихэд гадаад хамтын ажиллагааг чиглүүлэх, хөрш орондоо сурталчлан таниулах замаар гадаад зах зээлд бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэх, харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжийг бүрдүүлж ажиллах талаар санал солилцлоо.</p> <p>Оросын холбооны улсын “Эрхүү нутгийн гар урлалын хурим найр-2019” үзэсгэлэн худалдаанд хувиараа хөдөлмөр эрхлэгч 5 иргэний зардалд ХЭДС-аас 1,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үйлдвэрлэгчид үзэсгэлэн худалдааны “Гранпри” шагналыг хүртэж 3,2 сая төгрөгийн борлуулалт хийжээ. Монголын худалдагчийн нэгдсэн холбоо, МХАҮТ-ын салбар, Дундговь аймгийн худалдагчдын холбоо, СХЗХ-тэй хамтран худалдагчийн мэргэжил олгох сургалтыг 10 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулж 56 иргэнийг хамруулан сургаж үнэмлэх олголоо.</p> <p>Худалдаа эрхлэгчдийн уулзалтыг 2019 оны 10 дугаар сард зохион байгуулж шинэчлэгдэн батлагдсан Монгол улсын MNS 5021-1:2019 “Жижиглэн худалдаа газар, түүний үйлчилгээ” стандартын талаар мэдлэг олгох цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ярилцсан уг үйл</p>
--	-----------------------------	--	--	--	--

						ажиллагаанд нийт 30 гаруй байгууллагын төлөөлөл оролцож санал бодлоо солилцлоо. Стандарт хангалтын түвшин тогтоох шалгалтыг 11 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлүүлээд байна	
4.4.2	АЗДҮАХ 4.2.7 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.2.7	“Дундговь түншлэл 2019” үзэсгэлэн худалдааг үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх үүднээс 9 дүгээр сард төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Удирдамж чиглэлийг гаргаж хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэж үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байх	Оролцогчийн болон бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж борлуулалтын орлого өмнөх оноос өссөн байна.	2,5 ОНТ 1,3 Хандив тусламж	1 дүгээр сарын 23,24-ны өдрүүдэд Цагаан сар-2019 үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 44 иргэн, 8 ААНэгж 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 33,6 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан. Аймгийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдан борлуулах зорилгоор “Дундговь Түншлэл-2019” үзэсгэлэн худалдааг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Ажил олгогч эздийн холбооны Дундговь аймаг дахь салбар хамтран 2019 оны 9 дүгээр сарын 20, 21-ны өдрүүдэд 15 дахь жилдээ амжилттай зохион байгуулллаа. Үзэсгэлэн худалдаанд өөрийн аймгийн 15 сум, Улаанбаатар, Сэлэнгэ, Төв аймгийн 130 гаруй үйлдвэрлэгчид оролцож 54,2 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх онтой харьцуулахад оролцогчийн тоо 6,9, борлуулалт 1,1 хувиар тус тус өссөн байна.	100
Нийт арга хэмжээ-13. Үүнээс 100 хувьтай 11, 70 хувьтай 1, Үнэлэх боломжгүй 1							97,5

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Ю.ГАНЦЭЦЭГ

ХЯНАСАН: ХХААГ-ЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ